



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 04 сарын 03-адар

Дугаар 02

Улаанбаатар хот

“Монголд зочлох жил”-ийн хүрээнд
зам, тээврийн салбарт авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

1. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023-2025 онд “Монголд зочлох жил”-ийг аялал, жуулчлалын тээврийн дэд бүтцийг сайжруулах, тадаадын болон дотоодын зорчигчдод үзүүлэх тээврийн үйлчилгээний хүртээмжийг дээшшуулэх, аяллын тоо, зорчилгээний нэмэгдүүлэх, аяллын тийзний чунаууруулах, тээврийн үйлчилгээг бурэн чиглэл нэмэгдүүлэх, аяллын тийзний чунаууруулах, тээврийн аюулгүй байдлыг сайжруулах, цахимжсан, хялбар, хүнд сурталгүй хургэх, тээврийн аюулгүй байдлыг сайжруулах, зорилтын хүрээнд зохион нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах зорилтын хүрээнд зохион байгуулсугай.

2. Дээрх зорилтын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллага, салбарын төрийн ёмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэж, компаниудын салбарын төрийн ёмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэж, компаниудын зорилтуудад дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд: удирдлага, захирлуудад дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

2.1. “Монголд зочлох жил”-ийн лого, танилцуулгыг салбарын албан байгууллагуудын шахим хаяг, тээврийн хэрэгсэл, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төвүүд, тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн зорчигчдод зориулсан дэлгэц, танилцуулах материал дээр байршуулах;

2.2. Харьяа байгууллага, төрийн ёмчит компаниуд “Монголд зочлох жил”-ийн (2023-2025) хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүрээр гарган баталж, хэрэгжилтийг хангах;

2.3. Харьяа байгууллагууд “Монголд зочлох жил”-тэй холбоотой медиа контент, сурталчилгааны бүх төрлийн материал бэлтгэж, нэгдсэн мэдээлэл, удирдлагаар хангах;

2.4. Зам, тээврийн салбарт аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжуулж, бүх төрлийн тээврийн зорчигч тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмж, тээврийн аюулгүй байдлыг сайжруулах;

2.5. Зам, тээврийн салбарын либералчлалыг өргөжүүлж, хоёр талт болон олон талт хэлэлцээрүүдийг гадаад улс орнуудтай байгуулах, олон улсын гэрээ, конвецид нэгдэн орох, дотоодын хууль эрхэүйн орчныг сайжруулах чиглэлд дорвитой ахиж гаргах;

080000010

2.6.Харьяа байгууллагууд, төрийн өмчит компаниуд гадаад, дотоодын жуулчдад үзүүлдэг үйлчилгээг бүрэн цахимжуулж, хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлэх;

2.7.“Монголд зочлох жил”-ийн хүрээнд нисэх онгоцны буудал, төмөр замын буудал, автобуудал, зам дагуух үйлчилгээний цогцолбор болон замын хажуугийн түр зогсоол, жуулчдад үйлчилгээ үзүүлэх төв, тээврийн үйлчилгээний газруудын хаяг, өнгө үзэмжийг сайжруулах, үйлчилгээний газрын хаяг, танилцуулгыг монгол, англи болон шаардлагатай тохиолдолд бусад гадаад хэл дээр байршуулах;

2.8.Зорчигч тээврийн үйлчилгээний албан хаагчдын дүрэмт хувцсыг шинэчлэх, сайжруулах, байгууллагын цахим хуудсыг англи болон бусад хэлээр хөтлөх, жуулчдад чиглэсэн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж байх,

2.9.Орон нутгийн нисэх буудал, төмөр замын буудал, автобуудлуудын үйл ажиллагаа, тохижилтийг сайжруулж, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.10.Олон улс, дотоодын зорчигчийн нислэг, галт тэрэгний аялал, автотээврийн үйлчилгээний батлагдсан цагийн хуваарийг чанд баримтлан ажиллах, хуваарыт аяллыг цуцлахгүй байх; аливаа давагдашгүй хүчин зүйлийн нэлөөнд аялал цуцлагдсан эсхүл хойшлогдсон тохиолдолд мэдээллийг урьдчилан хүргэх, дараагийн аялалд шилжүүлэх, эсвэл тийзийн үнийн буцаан олголтыг зорчигчдод бүрэн, чирэгдэлгүй буцаан олгох;

2.11.Зорчигч тээврийн бүх төрлийн тээврийн хэрэгслийн дотор болон гадна өнгө үзэмж, үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгслүүд нь стандартын шаардлага хангасан байх, техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг, оношилгоо хийж, аюулгүй ажиллагааг хангуулах;

2.12.Олон улс, хот хоорондын зорчигч тээвэрт оролцогч үйлчилгээний ажилтан, тээвэрчид, үйлчлэгч бусад албан хаагчдын үйлчилгээний соёл, англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

2.13.Зам, тээврийн салбарт олон улс, орон нутгийн аяллын тоо, чиглэл нэмэгдүүлэх, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, хүртээмжтэй болгох, аяллын тийзийн үнэ бууруулах чиглэлд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.14.Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллагууд, салбарын төрийн өмчит компаниуд “Монголд зочлох жил”-ийн хүрээнд авч хэрэгжүүлж буй сайн туршлага, шинэлэг ажлуудыг олон нийтэд сурталчлах, таниулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

2.15.Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх, тийзийн үнийн хөнгөлөлт үзүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх;

2.16.Байгаль орчинд ээлтэй тээврийн үйлчилгээг өргөжүүлэх, салбарын хэмжээнд хог хаягдал, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлд томоохон төсөл

хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, олон улсын байгууллага, тэр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах төлөвлөгөө гарган ажиллах;

Иргэний нисэхийн өрөнхий газарт

2.17."Чингис хаан" ОУНБ-ын зорчигч үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлуудыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор дуусгаж, ашиглалтад оруулах;

2.18.Орон нутгийн нислэгийг сэргээх, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд тодорхой шийдвэр гаргах, бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх;

2.19.Агаарын тээвэрлэгчдэд шинэ чиглэл нээхэд шаардлагатай томилгоо, тусгай зөвшөөрлийг бодит судалгаанд үндэслэн нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, шуурхай шийдвэрлэх;

МИАТ ТӨХК-д

2.20.Орон нутгийн нислэг үйлдэх боломжтой агаарын хөлөг оруулж ирэх, ашиглах, орон нутгийн нислэг сэргээх чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-т

2.21.Улс хоорондын болон хот хоорондын зорчигч тээвэрлэгчдэд шинэ чиглэл нээхэд шаардлагатай томилгоо, зөвшөөрлийг бодит судалгаанд үндэслэн нээлттэй, ил тод, хүнд сурталгүй шийдвэрлэх;

2.22.Улс хоорондын болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний хүртээмж, аюулгүй байдлыг хангах, батлагдсан цагийн хуваарийн дагуу тээврлэлтийг гүйцэтгэх зэрэг тээврлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

2.23.Олон улс, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг бүрэн цахимжуулах арга хэмжээ авах;

2.24.Автозамын хажуугийн үйлчилгээний цогцолбор, түр зогсоолын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний цогцолборуудад байх зайлшгүй үйлчилгээний төрлүүдийг шинээр бий болгох, хяналт тавих;

Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-т

2.25.Шаардлагатай чиглэлүүдэд авто замын засвар, арчлалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, аялал жуулчлалын улирал эхлэхээс өмнө замын засвар, арчлалтыг дуусгах;

2.26.Автозамын тэмдэг, тэмдэглэгээ, замын хажуугийн мэдээллийн самбарт зорчигчдод шаардлагатай мэдээллийг монгол, англи болон бусад хэлээр байршуулах;

2.27.Төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх;

Улаанбаатар төмөр зам ХНН-т

2.28.Тэмэр замын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээх, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах, зорчигчдын тав тухтай байдлыг хангах чиглэлд арга хэмжээ авч ажиллах;

Далайн захиргаанд

2.29.Хөвсгөл, Тэргийн цагаан, Өгий, Хяргас, Буйр зэрэг томоохон нуурын усан зогсоол, усан замын тээврийн хэрэгсэлд тогтоосон хугацаанд техникийн үзлэг хийж, бэлэн байдлыг хангуулах, завьчдын мэргэжлийн үнэмлэхийг шалгах ажлыг зохион байгуулах;

3.Зам, тээврийн салбарт "Монголд зочлох жил"-ийн хурээнд хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнах, гарсан үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг харьяа байгууллага, салбарын териин емчийн компаниудын удирдлага, захирлуудад үүрэг болгосугай.

4.Нийт тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд оруулах, тээврийн аюулгүй байдлыг хангах, автозамын бэлэн байдлыг шалгаж, холбогдох тайланг улирал тутам танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий)-т даалгасугай.

5.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал тутам танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

